МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

# ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

# САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.БАТБОЛДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.БАТБОЛДЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтод түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Хугацаа | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | **САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| **1.2.** | **Орон сууцжуулалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх. /Үндэсний орон сууцжуулалтын тогтолцоо, Хуримтлалын сангийн реформыг хэрэгжүүлэх;/** | | | | | | |
| 1.2.1. | **Арга хэмжээ:** Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны төслийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулна.<br><br>**ЗГҮАХХҮТ 3.7.9.9** | -Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах тандан судалгаа - 1<br>-Судалгааны үр дүнг шинээр бүрэлдсэн Засгийн газарт танилцуулах - 1 | -“Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам” Барилга, хот байгуулалтын Сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар баталсан. | Хуулийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг хийж, гарсан үр дүнг шинээр бүрэлдсэн Засгийн газарт танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. | Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн хэрэгцээ, шаарлагын тандан судалгааг боловсруулж, зорилтот бүлгийн иргэдийг төлбөрийн чадварт нийцсэн хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, цогц тогтолцоог бий болгох шаардлагатай гэж дүгнэн, холбогдох хуулийн төслийн хамт Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар “Орон сууцжуулалтын талаар 2024-2028 онд баримтлах бодлого, чиглэл”-ийг танилцуулсан. Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлүүлсэн. | | |
| 1.2.2 | **Арга хэмжээ:** Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, корпорацыг шинээр байгуулна.<br><br>**ЗГҮАХХҮТ 3.7.8.1** | -Хуулийн үзэл баримтлал<br>-Зардлын тооцоо<br>-Үр нөлөөний үнэлгээ<br>-Хуулийн төсөл<br>-Дагалдах хуулийн төсөл<br>-хуулийн зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах | - | Үндэсний орон сууцны санхүүжилтийн корпорац байгуулах хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулж, зөвлөх үйлчилгээний хуулийн фирмийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна. | Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулсан.<br><br>Орон сууцжуулалтын тухай хуулийн үзэл баримтлал Барига, хот байгуулалтын сайд, Сангийн сайд, Хууль зүйн, дотоод хэргийн сайд нараар батлуудсан.<br><br>Хуулийн төсөл, түүний хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, үзэл баримтлал, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ, дагах хуулийн төсөлийг боловсруулан Засгийн газарт өргөн барьж, ЗГ-ын 2024 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдсэн.<br><br>Улсын Их Хуралд 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр өргөн барьж Эдийн засгийн байнгын хороогоор 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцэн дэмжигдсэн. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэн дэмжигдэж анхны хэлэлцүүлгийн бэлтгэлийг хангахаар Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугараар ахлуулсан ажлын хэсэгт шилжүүлсэн.<br>УИХ ээлжит сонгууль болж хуулийн төслийг ЗГ-т буцаасан.<br><br>Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар “Орон сууцжуулалтын талаар 2024-2028 онд баримтлах бодлого, чиглэл”-ийг танилцуулсан. Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлүүлсэнтэй холбоотойгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын 2024 оны 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 107 дугаар тушаалаар Орон сууцжуулалтын тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр анхны ажлын хэсгийн анхны хурал зохион байгуулагдсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөлд зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаварыг боловсруулан, сонгон шалгаруулж 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 2024/159 дугаартай хамтран ажиллах гэрээг "Легал инновешн хаав" ХХК-тай байгуулсан.<br><br>Хуулийн зөвлөх үйлчилгээний компанитай 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр уулзаж, холбогдох чиглэлийг өгч ажилласан. | | |
| 1.2.3 | **Арга хэмжээ:**<br>Бага, дунд орлоготой иргэдийг жилийн 4-6 хувийн хүүтэй, хөнгө-лөлттэй зээлд хамруу-лах эрх зүйн орчныг бүрдүүлж, зээл олгох ажлыг холбогдох бай-гууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна.<br><br>**ЗГҮАХХҮТ 3.7.10.1** | -Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэдийн тоо, өссөн дүнгээр | Ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийг 2023 оны өссөн дүнгээр 36504 иргэнд олгосон. | Ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийг өссөн дүнгээр 38476 иргэнд олгосон байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар Уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны цэвэр ашгаас нийт 499.5 тэрбум төгрөгийг хуримтлалын сангаар дамжуулан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн.<br><br>Ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 1,287.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 10,983 зээлдэгчид олгосон.<br><br>Хөдөө, орон нутагт олгох 3 хувийн ипотекийн зээлийн хөтөлбөр 2023 оноос хэрэгжиж эхэлснээс хойш 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл нийт 3,898 иргэний 386.3 тэрбум төгрөгийн зээлийг шийдвэрлээд байна /2023 онд 993 иргэн, 83.4 тэрбум төгрөг, 2024 онд 2,905 иргэн, 302.9 тэрбум төгрөг/. Үүнээс: Орхон аймаг 765 иргэний 85.5 тэрбум, Дархан-Уул 416 иргэний 43.0 тэрбум, Дорнод 250 иргэний 22.8 тэрбум төгрөгийн зээл олгосон нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.<br><br>Тус үйл ажиллагааны хүрээнд 2021 онд 13,292 иргэн, 2022 онд 7,847 иргэн, 2023 онд 8,889, 2024 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 10,983 иргэн, нийт 35,147 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд нэмж хамруулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хоёрдугаар хавсралтаар баталсан ипотекийн зээлд хамрагдсан 6,476 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэдийн суурь тоог, 41,011 иргэнээр нэмэгдүүлж 2024 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 47,487 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна. | | |
| 1.2.4 | **Арга хэмжээ:** Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн тодорхой хэсэгт зээлийн батлан даалт гаргуулна.<br><br>**ЗГҮАХХҮТ 3.7.10.1** | -Зээлийн батлан даалт гаргасан тоо | Ипотекийн зээлд батлан даалт гаргасан төгрөгийн хэмжээ 2,386.6 сая төгрөг<br>Батлан даалт гаргасан зээл:<br>-31 Орхон аймаг,<br>-24 Дорнод аймаг,<br>-23 Дархан-Уул аймаг,<br>-11 Дорноговь аймаг,<br>-9 Хөвсгөл, Сэлэнгэ, Баянхонгор. | -Ипотекийн 500 зээлд батлан даалт гаргасан байна | Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд өөрчлөл оруулж Улсын 2024 оны төсөвт 50.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Зээлийн батлан даалт гаргах үйл ажиллагаан зориулан баталсан бөгөөд Хөдөө, орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт 2023 оноос батлан даалт гаргадаг болсноос хойш 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл нийт 1211 иргэний 129.3 тэрбум төгрөгийн зээлд 24.5 тэрбумын төгрөгийн урьдчилгаа төлбөрийн батланд даалт хийгээд байна. Үүнээс 2024 онд ипотекийн 1211 зээлд 24.5 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргаад байна.<br>Батлан даалтыг хамгийн их 196 Орхон, 132 Дорнод, 110 Баянхонгор, 76 Сүхбаатар, 71 Өвөрхангай, 69 Говь-Алтай, 63 Сэлэнгэ, 61 Дархан-Уул аймгуудад тус тус гаргаад байна. | 01-12 | 100 |
| 1.2.5 | **Арга хэмжээ:** “Баян-голын амны орон сууц” барих төслийг хэрэг- | -Төслийн удирдах хорооны | Төслийн ТЭЗҮ-г боловсруулж, зээлийн гэрээг байгуулан, зөв- | Төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхэд НЗДТГ-т | 2024.02.24-нд ТУХ-ны III хурал болж төслийн 2024 оны үйл ажиллагааны, санхүүгийн болон | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | жүүлэх ажлыг зохион байгуулна.<br><br>**ЗГҮАХХҮТ 3.7.9.3 МУХОХ 36** | хуралд оролцох.<br><br>-Саналын тоо | лөх үйлчилгээний багийг сонгон шалгаруулсан. | дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна. | худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнүүдийг баталсан.<br>НЗД-ын 2024.01.10-ны А/20 захирамжаар байгуулагдсан "Төслийн барилга угсралтын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо"-оос Төслийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шал-гаруулах тендерийг 2024.03.01-нд зарлаж, тендерт оролцогч-дыг үнэлж эцсийн дүгнэлт гарган, тендерт шалгарсан Солонгос Улсын ILSUNG байгууллагатай НЗДТГ гэрээ байгуулах шатанд шилжсэн. | | |
| 1.2.6 | **Арга хэмжээ:** Эко яармаг-1 гэр хороол-лын дахин төлөвлөл-тийн төслийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.<br><br>**МУХОХ 38** | Төслийн хэрэгжилт, хувь | -Магадлалаар хянагдан дүгнэлт гарсан Төслийн шинэчилсэн иж бүрдэл зураг төсөл 1 /100%/<br>-Төслийн талбайг чөлөөлөх ажил 100%<br>-Ашиглалтад хүлээлгэн өгсөн цахилгааны дэд өртөө 1 | Төслийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд "Төрийн орон сууцны корпорац" ТӨХХК-ийг нэгдсэн удирдлага, чиглэлээр хангаж, тухай бүр дэмжлэг үзүүлж, холбогдох байгууллагуудтай хамтарсан уулзалтыг зохион байгуулж ажилласан байна. | Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа Наадамчдын зам дээгүүр барих 800у/м гүүрэн байгууламж төслийн талбайтай дахцаж байгаатай холбоотой-гоор ТОСК, замын зураг төсөл боловсруулж байгаа байгууллага-га, Төслийн зураг төсөл боловсруулсан байгууллагыг холбон 2 удаагийн зөвшилцөх уулзалт хийж төслийн барилгажилтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан төслийг НАЗХГ-тай зөвшөөрөлцсөн бөгөөд нийслэлийн Ерөнхий архитектороор хянуулан баталгаажуулахаар хүргэгдсэн.<br>Төслийн төлөвлөлтийн дагуу гадна цахилгаан хангамжийн сүлжээний чиглэл, зурвас өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл дахин | 01-12 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулагдсан. Эрчим хүчний яамнаас Цахилгаанаар хангах техникийн нөхцөл хүлээгдэж байна.<br>Хэрэгжилт удаашралтай | | |
| 1.2.7 | **Арга хэмжээ:** Орлогод нийцсэн 10,000 орон сууцны эко хорооллын төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.<br><br>**ЗГҮАХХҮТ 3.7.9.4** | -Төслийн удирдах хорооны хуралд оролцох.<br><br>-Төслийн хэрэгжилтийн хувь | Баянхошуу дэд төвийн эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажил 45%,<br>Шархад дэд төвийн эхний ээл-жийн 110 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажил 30%,<br>Баянхошуу дэд төвийн инженерийн шугам сүлжээний угсралт 40%. | БХБЯ-ны зүгээс эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй орон сууц төлөвлөхөд дэмжлэг үзүүлж, Төс-лийн удирдах хорооны хуралд оролцож, удир-длага, арга зүйн чиглэ-лээр хангаж ажилла-сан байна. | ТУХ-ны 2024 оны I хуралдаан 2024.02.27-нд болж 2024 онд хэрэгжүүлэх нийт үйл ажилла-гаа, худалдан авах ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөөг баталж, төслийн ажилтнуудын 2024 оны хөлсөөр ажиллах гэрээг сунгах, төслийн II бүрэлдэхүүнээр хэ-рэгжүүлэх эко хорооллуудын талбарыг тодорхойлох, ухаалаг удирдлагын нэгдсэн төвийг хөгжүүлэх асуудлуудыг хэлэлцэн хуралдааны тогтоол, зөвлөмж гарсан. 2024 оны нийт төсөв 151.8 тэрбум төгрөгөөр баталснаас СЯ-аас 52,3 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан.<br>Баянхошуу дэд төвийн Б15 талбарын 110 айлын орон сууцны барилга угсралт 90%<br>Эхний ээлжийн 110 айлын орон сууцад зориулсан гадна ИШС-ний барилга угсралт бүрэн дуусч 2024 оны 10 сарын 01-ний өдөр ашиглалтад хүлээн авах комисс зохион байгуулагдсан.<br>Баянхошуу дэд төвийн Б13-1 талбарт 2024 оны 7 сард эхэлсэн 150 айлын орон сууцны барилгын ажил 35%<br>Баянхошуу дэд төвийн Б13-2 талбарт 2024 оны 10 сард эхэлсэн | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 76 айлын орон сууцны барилгын ажил 10%<br>Шархад дэд төвийн S27-5 талбарын эхний ээлжийн 110 айлын орон сууцны барилгын ажил 85%<br>Шархад дэд төвийн лэл бүтцийн барилга байгууламжийн угсралтын ажлыг 2024 оны 7 сараас эхлүүлэн бүрэн дууссан.<br>Шархад дэд төвийн S27-2 талбарт баригдаж буй 152 айлын орон сууцны барилгын ажил 35%<br>Шархад дэд төвийн 2-аар ээлжийн 76 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендео зарлагдаж, материал ирүүлсэн 4 аж ахуйн нэгжийн тендерийн баримт бичгийг үнэлэх ажил хийгдэж байна. | | |
| 1.2.8 | **Арга хэмжээ:** “Залуус-1” орон сууцны хороо-лол барих төслийг хэрэгжүүлнэ.<br><br>**ЗГҮАХХҮТ 3.7.9.7 ШСБҮАХХХТЖ 17 МУХТ 6.2.1.1.** | -Төслийн гадна инжене-рийн шугам сүлжээний аж-лын гүйцэт-гэл; | Дулааны шугам сүлжээний ажил 65%, Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажил 60%, Хонгилын системийн угсралтын ажил 68%, Цахилгаан хангамжийн | Төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлыг батлагдсан төсвийн хүрээнд бүрэн хэрэгжүүлнэ. | Төслийн шугам сүлжээний угсралттай холбоотой ажлуудыг НААИДББХЗГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан.<br>ИШС-ний угсралтыг үргэлжлүүлэх ажил 2024 оны улсын төсөвт батлагдсан 12.7 тэр бум төгрөгийн хүрээнд 2024.03.25-аас эхэлсэн. Гадна дулааны шугам сүлжээ байгууламжийг “Одкон холдин” ХХК 95% гүйцэтгэлтэй барилгын ажлыг хийж 2024.11.10-нд 2025 онд үргэлжлүүлэн гүйцэтгэхээр улирлын зогсолт хийсэн. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | угсралтын ажил 65% | | Хорооллын гадна инженерийн шугам сүлжээний хонгилын системийн барилга угсралт “Биг монгоиа бюлдинг” ХХК 70%-ийн гүйцэтгэлтэй хийж 2024.10.10-нд 2025 онд үргэлжлүүлэн гүйцэтгэхээр улирлын зогсолт хийсэн.<br>Төслийн гадна цахилгаан хангамжийн шугам сүлжээний барилга байгууламжийн угсралтыг 75%-ийн гүйцэтгэлтэйгээр “Өи Эс Би Инержи” ХХК гүйцэтгэн 2024.11.15-нд 2025 онд үргэлжлүүлэн гүйцэтгэхээр улирлын зогсолт хийсэн.<br>“Алтайн үндэс” ХХК төслийн гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний барилгын ажлыг 100% хийж гүйцэтгэсэн. Усны насосны үнэд өөрчлөлт орсонтой холбоотойгоор насос сонгох ажлыг Ус сувгийн удирдах газартай зөвшилцөх ажил хийгдэж байна.<br>“Залуус-1” орон сууцны хороолол барих төслийн хүрээнд баригдах Дулааны цахилгаан станцын барилгын ажлын зураг төсөлд “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ хамтран магдалал хийсэн. | | |
| 1.2.9 | **Арга хэмжээ:** Үндэсний орон сууцны | -Саналын тоо-1 | - | Хуримтлалын сангийн зарцуулалт хийх журмын ажлын хэсэгт орж ажиллаж, | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/106 дугаартай тушаалаар байгуулагдсан Монгол | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуримтлалын сан байгуулна. | | | шаардлагатай судалгаа мэдээллээр хангасан байна. | Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмын төсөл, боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, салбар хоорондын уялдааг хангах, холбогдох чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсэгт орж, шаардлага судалгаа мэдээллээр ханган ажилласан.<br><br>Засгийн газрын “Журам батлах тухай” тогтоолын төсөлд санал авахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 1/1621 дугаартай албан бичгийг Засгийн газрын гишүүдэд хүргүүлсэн.<br><br>2024 оны 09 дүгээр сард “Хуримтлалын сангийн үйл ажиллагаа ба орон сууцны тогтвортой санхүүжилт"-ын талаар албан уулзалтыг ХББОС-ын сайд Ж.Батсуурь, ГБХНХ-ын сайд Л.Энх-Амгалан, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” утүг-ын захирал Д.Зоригт болон холбогдох албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж, санал солилцов. | | |
| 1.2.10 | **Арга хэмжээ:** Бүсчилсэн хөгжлийн бодлого болон хэсэгчилсэн ерөнхий | -Шилжин суурьшсан өрхийн орон сууцны ипотекийн | - | Хөдөө, орон нутагт ипотекийн зээлд хамрагдсан өрхийн нийт зээл олголтод | Улсын Их Хурлын “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2023 оны 93 дугаар тогтоолын 2.1-д орон | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөний дагуу хөдөө, орон нутагт хот суурин газрыг хөгжүүлэн Улаанбаатар хотын төвлөрөл, ачааллыг бууруулсан байна. **ШСБ-4.2.7** | зээлд хамрагдалтын хувь | | эзлэх хувийг 40%-д хүргэнэ. | сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэй хуваарилахыг Засгийн газарт даалгасаны дагуу 2024 онд олгосон нийт зээлийн 54.3 хувь буюу 5963 иргэний 769.49 тэрбум төгрөгийн зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 45.7 хувь буюу 5020 иргэний 517.96 тэрбум төгрөгийн зээлийг орон нутагт олгосон.<br><br>Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан 54 өрх орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан нь өмнөх онтой харьцуулахад 25.6 хувиар өссөн байна. | | |
| 1.2.11 | **Арга хэмжээ:** Иргэдийн орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцө-лийг бүрдүүлэх зорил-гоор орон сууцжуула-хад чиглэсэн төсөл, арга хэмжээг тухайн орон нутгийн онцлог, дэд бүтцийн бэлэн байдал, иргэд, зорилтот бүлгийн шаардлагатай уялдуулан зохион байгуулах; | Орон нутгийн дэд бүтцийн бэлэн байд-лын судалгаа | - | Төрийн албан хааг-чийн болон түрээсийн орон сууцны нэг мая-гийн загвар зургийн төсөл 3<br>Орон нутгийн дэд бүтцийн бэлэн байдлын судалгааг боловсруулж танилцуулсан байна. | Дэд бүтцийн нэгдсэн ИШС-тэй, хот суурин газрын ерөнхий төлөвлөгөөтэй аймаг, сумын төв, суурин газруудын мэдээл-лүүдийг холбогдох байгууллага, орон нутгаас авч судлан жагсаалт гаргасан. Жагсаалтаар засаг захиргааны нэгжийн хувьд 115 сумын төв, нийслэлийн алслагдсан 3 дүүргийн төв, нийт 118 суурин газрын жагсаалт гарсан.<br>Улсын магадлалаар хянагдаж баригдсан Дорноговь аймгийн захиалгаар хийгдсэн 8 айлын, Өмнөговь аймгийн захиалгаар хийгдсэн 10 айлын орон сууцны барилгын зураг төслийн загвар зургийг БХТ-ийн 2024.05.01-ний | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **УИХ 2023 оны 93 дугаар тогтоол-1.1** | | | | 1/1108 тоот албан бичгээр хүлээн авсан.<br>Говь-Алтай аймагт орон нутгийн захиалгаар зохиогдон, улсын магадлал хийгдсэн 15 айлын орон сууцны барилгын загвар зургийг аймгийн Ерөнхий архитектороос ирүүлсэн. | | |
| 1.2.12 | **Арга хэмжээ:** Орлогод нийцсэн, тэсвэртэй орон сууц барих, санхүүжүүлэх бодлогын хувилбарууд" сэдэвт форумыг Дэлхийн банктай хамтран зохион байгуулах. | Хэлэлцүүлгийн тоо-1 | Төрөөс иргэдийг орон сууцжуулах бодлогын төсөл боловсруулсан | Орлогод нийцсэн, тэсвэртэй орон сууц барих, санхүүжүүлэх бодлогын хувилбарууд" сэдэвт форумыг Дэлхийн банктай хамтран зохион байгуулсан байна. | Монголын орон сууцжуулалтын ирээдүй – 2024 олон улсын форумыг 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр амжилттай зохион байгуулж форумаас гарсан үр дүн, санал зөвлөмжийг аймаг, нийслэл, холбогдох байгууллагуудад 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн.<br>Форумаас гарсан үр дүн, санал зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төслийг боловсруулан ТНБД-аар батлуулахаар ажиллаж байна. | 09-12 | 100 |
| 1.2.13 | **Арга хэмжээ:** Орон нутагт амжилттай хэрэгжүүлсэн орон сууцжуулах сайн туршлагыг судлах. | Санал-1 | - | Орон нутагт хэрэгжүүлэх орон сууцжуулалтын сайн хувилбарыг судлан танилцуулсан байна. | 1. ТНБД-ын 2024.10.17-ны өдөр баталсан удирдамжын хүрээнд Архангай аймгийн Цэцэрлэг хот, Ихтамир, Эрдэнэмандал, Цэнхэр, Хотонт, сумдын төв, Завхан аймгийн Улиастай хот, Алдархаан сумын төвд 2024.10.21-25-ны өдрүүдэд ажиллан, сумдын ерөнхий төлөвлөгөө, түүний хэрэгжилт, орон сууцжуулах үйл ажиллагаатай холбоотой төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл байдлын талаар танилцсан. Үүний үр дүнд: | 09-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Архангай, Завхан, Баянхонгор, Баян-Өлгий, Ховд аймгийн төвүүдэд хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу улсын төсвөөр гадна инженерийн шугам сүлжээний угсралт хийсэн шинэ орон сууцны хорооллын газарт орон сууцжуулалтын талаар зорилтод арга хэмжээг авах, орон сууцны үнийг тогтвортой барих зорилгоор орон сууцны зориулалттай зарим газрыг орон нутгийн өмчит байгууллага болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын нэр дээр газар эзэмших эрхийг авсан.<br>- Архангай аймгийн Цэцэрлэг хотын шинэ орон сууцны хорооллын нам давхрын, эдлэн газартай амины сууцны бүсэд Барилгын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасныг удирдлага болгон амины орон сууцны зураг төслийг батлуулсны үндсэн дээр барилгажуулах нөхцөлийг газар эзэмшигч, өмчлөгчид тавьсан,<br>- Архангай аймгийн Эрдэнэмандал сумын төвийн нийтийн аж ахуйн асуудлыг хариуцсан тусгай зөвшөөрөл бүхий орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулж, төвийн гадна инженерийн шугам сүлжээнд иргэн ААН-ын барилга, байгууламжийг холбох ажлыг шуурхай шийдвэрлэж, зардал багатайгаар холбох ажлыг хийж гүйцэтгэн, ИШС-ний ач | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдолыг олон нийтэд сурталчилах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүний үр дүнд сумын төвийн айл өрх, албан байгууллагуудаас төвийн шугам сүлжээнд холбогдох хүсэлт нэмэгдэж байгаа орон нутгийн сайн туршлага бүхий давуу талууд байна.<br>2. Орон нутгуудад орон сууцжуулалттай холбоотой хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгаагаар дараах ололттой, сайн туршлагууд байна. Үүнд:<br>- Хэнтий, Архангай, Орхон, Говь-Алтай, Төв, Сүхбаатар аймгууд орон нутгийн орон сууцжуулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий ОНӨҮГ-ыг байгуулан түүгээр дамжуулан орон сууц барих ажлыг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж байгаа,<br>- Алслагдсан сум, суурин газруудад төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор Говь-Алтай, Баянхонгор, Дорноговь, Өвөрхангай, Төв аймгуудад төрийн албан хаагчийн хэрэгцээ бүхий сумын төвүүдэд төрийн албан хаагчын орон сууцны зориулалтаар орон нутгийн мэдэлд газрын шийдвэр гаргуулсан, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Дорнод, Дундговь, Өмнөговь аймгууд алслагдсан сум, суурин газарт 8, 10 айлын төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны барилгын зураг төслийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж, улс орон нутгийн төсвийн санхүүжилтээр барих ажлыг зохион байгуулсан,<br>- Говь-Алтай аймаг аймгийн төвийн сумаас бусад суурин газар нэгдсэн 120 айлын орон сууцны хотхоны цогцолбор зураг төсөл боловсруулан төр хувийн хэвшлийн хамтын ажиллаганы хүрээнд эхний 1 суманд барилгажилтын ажлыг эхлүүлсэн<br>- Дорноговь аймагт Сайншанд, Замын-Үүд сумын төвд орон сууцны төслийг төрийн бус байгууллагатай хамтран барилгажилтыг үе шаттай хийж, хэрэгжүүлж байгаа,<br>- Сүхбаатар, Орхон, Баян-Өлгий аймгуудад орон сууцны төсөл арга хэмжээг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран зохион байгуулахаар төсөл зарлан, хамтын ажиллагааны гэрээ байгуулж, хэрэгжүүлж эхэлсэн,<br>- Дорноговь, Өмнөговь аймгууд түрээсийн орон сууцны санг бий болгох зорилгоор орон нутгийн төсөвт санхүүжилтийн хөрөнгө суулган зах зээл дээр борлогдож байгаа орон сууцнаас худалдан авалт хийх сонгон шалгаруулалт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарласан зэрэг сайн туршлагууд байна. | | |
| 1.2.14 | **Арга хэмжээ:** Төрийн орон сууцжуулах бодлого, арга хэмжээ болон орон нутгийн сайн туршлагыг сурталчлах ажлыг зохион байгуулах. | Хэлэлцүүлгийн тоо-1 | - | Төрийн орон сууцжуулах бодлого, орон нутгийн сайн туршлагыг сурталчлан таниулах хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрөөс орон сууцжуулалтын талаар баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг танилцуулах болон орон нутагт хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, таниулах зорилгоор "Орон сууцжуулах Форум-2024" арга хэмжээг Сүхбаатар аймагт 2024 оны 09 дүгээр сарын 26-29-ний өдрүүдийн хооронд зохион байгуулсан. | 09-12 | 100 |
| 1.2.15 | **Арга хэмжээ:** Гамшигт тэсвэртэй, эрчим хүчний алдагдал багатай, дэвшилтэт технологи бүхий "Амины орон сууц"-ны загвар төсөл, материал, тоног төхөөрөмжийг олон нийтэд сурталчлах, иргэдэд хямд үнээр амины орон сууц барих талаар мэдээлэл өгч, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зэрэг чиг үүрэг бүхий "/ЧД, СХД, СБД, БГД- т Технологи дамжуулах төв"-ийг | Төсөл -1 | - | -Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд "технологи дамжуулах төв"-ийг байгуулах боломжтой газрын судалгаа хийж Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгсөн байна. төлөвлөгөөнд санал өгсөн байна.<br>-"Амины орон сууцны технологи дамжуулах төв"-ийн байгуулах төслийг боловсруулсан байна. | Нийслэл Улаанбаатар хотын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ЧД, СХД, СБД, БГД-т "Технологи дамжуулах төв"-ийн зориулалтаар санал өгсөн.<br>НЗД, НГЗА-нд 03/635 тоот албан бичгээр нийслэлийн гэр хорооллын бүсэд "Технологи дамжуулах" төвийн зориулалттай газрыг сонгон ХББОСЯ-ны нэр дээр газар эзэмших хүсэлтийг хүргүүлсэн.<br>"Технологи дамжуулах төв" -ийг Улаанбаатар хотын СД, ЧД, СХД, БЗД-үүдийн нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх баг сонгон шалгаруулалтыг 2024.11.06-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зарласан. | 09-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах ажлыг зохион байгуулах. | | | | | | |
| 1.2.16 | **Арга хэмжээ:** Ипотекийн зээлийн санхүүжилтийн журамд Амины орон сууцыг хамруулах асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах. | Журмын өөрчлөлт-1 | Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны А-295 дугаар тушаалаар баталсан журам | Монголбанктай хамтарч ипотекийн хөнгөлөлттэй зээлийн журамд холбогдох өөрчлөлтийг оруулсан байна. | Амины орон сууцны ипотекийн зээл олгоход тулгамдаж буй асуудлын талаар санал авахаар арилжааны банк (Хас; Голомт; Капитрон; Төрийн банк; Худалдаа Хөгжлийн банк)-ны төлөөлөлтэй 2024 оны 10 дугаар сарын 8-9 өдрүүдэд уулзалт зохион байгуулсан.<br>Ипотекийн зээлийн санхүүжилтэд Амины орон сууцыг хамруулах үйл ажиллагааг тодорхой болгох зорилгоор Монголбанктай хамтран ажиллаж, Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны А/295 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын 1.2.13 дахь заалтад 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр өөрчлөлт оруулж, “Амины орон сууц” гэх нэр томьёоны ойлголтыг нарийвчлан тодорхойлолсон.<br>Амины орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрт оролцогч арилжааны банкуудад журмын өөрчлөлт, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг үнэлэх үнэлгээний систем (BestGer), тавигдах шаардлагын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх уулзалтыг Монголбанктай хамтран 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. | 09-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.17 | **Арга хэмжээ:** Зарим сумдад загвар түрээсийн орон сууцны төсөл хэрэгжүүлэх. | Судалгаа-1 | | Түрээсийн орон сууцны төсөл хэрэгжүүлэх боломжтой газруудын судалгааг хийж танилцуулсан байна. | Хот, суурин газрын ерөнхий төлөвлөгөөнд орон сууцны бүсэд хамаарах, төрийн байгууллагын мэдэлд байгаа Түрээсийн орон сууцны барилгын төсөл хэрэгжүүлэх боломжтой орон сууцны зориулалттай газруудын мэдээллийг цуглуулсан. Цуглуулсан мэдээллээр 12 аймгийн 36 суманд нийт 61 байршил төрийн захиргааны болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр орон сууцны зориулалттай газар байна.<br>Аймаг, сумын төвд барих боломжтой улс, орон нутгийн төсвөөр боловсруулсан төрийн албан хаагчдын орон сууцны барилгын магадлалаар хянагдсан зургуудийн мэдээлэл цуглуулсан. Үүнд Говь-Алтай аймгийн захиалгаар хийгдсэн 15 айлын, Өмнөговь аймгийн захиалгаар хийгдсэн 10 айлын, Дорноговь аймгийн захиалгаар хийгдсэн 8 айлын орон сууцны барилгын зураг төсөл 2024 онд улсын магадлалаар хянагдан баталгаажсан байна.<br>Орон нутгийн хөгжлийн төвөөр тогтоосон 91 сумын төв суурин газруудаас Архангай аймгийн Эрдэнэмандал, Баянхонгор аймгийн Богд, Булган аймгийн Хутаг-Өндөр, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Өвөрхангай аймгийн Сант, Төв аймгийн Баянчандмань, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Хэнтий аймгийн Жаргалтхаан, | 09-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хөвсгөл аймгийн Тариалан, Ховд аймгийн Дарви нийт 10 сумдын төвд орон нутгийн засаг, захиргаатай хамтран төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг 2024.10.29-нд төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зарласан. | | |
| 1.2.18 | **Арга хэмжээ:** Орон сууцжуулалтын бодлого боловсруулж, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028” баримт бичгийн төсөлд тусгана. | Бодлогын баримт бичигт орон сууцжуулалтын талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тусгуулсан байна. | - | Орон сууцжуулалтын бодлого боловсруулж, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028” баримт бичгийн төсөлд тусгана. | Төрөөс иргэдийг орон сууцжуулах бодлогыг шинэчлэн боловсруулж, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т нийт 15 арга хэмжээг хариуцсан ажиллахаар бодлогын дунд хугацааны баримт бичигт тусгуулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлуулсан. | 09-12 | 100 |
| 1.2.19 | **Арга хэмжээ:** “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.4.1.7 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Амины орон сууц шинээр барихад төрөөс татаас олгох журам боловсруулах | Журмын төсөл - 1 | - | “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.4.1.7 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Амины орон сууц шинээр барихад төрөөс татаас олгох журмын төслийг боловсруулсан байна. | “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.4.1.7 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Амины орон сууц шинээр барихад төрөөс татаас олгох журам”-ын төслийг Засгийн газрын тогтоолын төслийн хамт боловсруулж, байгууллагын албан хаагчдаас санал авахаар 2024 оны 12 дугаар сарын 09-ний ERP цахим системд байршуулсан. | 09-12 | 100 |
| **Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Арга хэмжээ 3.1:** Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллана. | Саналын тоо | Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд | Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн байна. | Тайлант хугацаанд нийт 19 удаагийн хууль, тогтоолын төсөлд санал хүргүүлж, Улсын Их Хурлын гишүүний асуулгад мэдээлэл хүргүүлж ажилласан. Үүнээс: 3 Улсын Их Хурлын гишүүний асуулга, 4 хуулийн төсөл, 12 Засгийн газрын тогтоол. | 01-12 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 3.2:** Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллана. | Мэдээ, мэдээлэл | Шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр бэлтгэн, хүргэж ажилласан | Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг салбарын үнэн зөв, бодит мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна. | Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. | 01-12 | 100% |
| 3. | **Арга хэмжээ 3.3**: Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. | Ёс зүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна. | - | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад холбогдох хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй хуулийн хүрээнд ажилласан байна. | Тайлант хугацаанд хариуцсан чиг үүргээ биелүүлэх хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад холбогдох хуульд заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй хуулийн хүрээнд ажиллав. Энэ хүрээнд 2023 оны хөрөнгө, орлогын мэдүүлгээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд meduuleg.iaac.mn-сайтад хугацаанд нь байршуулав. | 01-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | **Арга хэмжээ 3.4:** Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх. | Өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байна. | - | Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан удирдлагаас өгсөн шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, ажилласан байна. | 2024 оны 08 дугээр сарын 05-ны өдрөөс хойш газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн. | 01-12 | 100% |
| 5. | **Арга хэмжээ 3.5** Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Өргөдөл, гомдол албан бичиг | | Төрийн албаны үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | Тайлант хугацаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан. Тус хугацаанд нийт 231 албан бичиг ирсэн ба үүний 70 нь хариутай бичиг ба ..... өргөдөл гомдол ирснийг тухай бүр шуурхай хуулийн хугацаанд нь холбогдох хариу, чиглэлийг өгөн ажиллаа. | 01-12 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** “Монгол улсын хот байгуулалтын дээд боловсролын чадавхыг бэхжүүлэх төсөл /S-QUAD/”-ийн хүрээнд БНСУ-д зохион байгуулагдах “Монгол улсын хот байгуулалтын салбарын мэргэжилтнүүдийн чадавх бэхжүүлэх сургалт”-д хамрагдах | Гэрчилгээ | - | 1 | БНСУ-д 2024.05.12-05.21-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан “Монгол улсын хот байгуулалтын салбарын мэргэжилтнүүдийн чадавх бэхжүүлэх сургалт”-д амжилттай хамрагдаж, гэрчилгээ авсан. | 01-12 сар | 100% |
| 2. | **Арга хэмжээ 2.** Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал боловсруулах Ажлын хэсэгт ажиллах | Гэрчилгээ | - | 1 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал боловсруулах Ажлын хэсэгт ажиллаж, талархлын гэрчилгээ авсан. | 01-12 сар | 100% |
| 3. | **Арга хэмжээ 3.** Төрийн худалдан авах ажиллагааны А3-ийн сургалтад хамрагдах | Сургалт | - | 1 | Төрийн худалдан авах ажиллагааны А3-ийн 2024 оны 10 дугаар сарын 7-17-ний өдрүүдэд сургалтад хамрагдсан. | 01-12 сар | 100% |

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:

САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАЯРБАТ

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(нэр)*

2024 оны ... сарын ... -ны өдөр

ТАЙЛАГНАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.БАТБОЛД

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(нэр)*

2024 оны ... сарын ... -ны өдөр